

**ANDROID ГАР УТСАНД СУУРИЛАГДСАН НӨАТУС ПРОГРАМ ХАНГАМЖ НИЙЛҮҮЛЭХ
ГЭРЭЭ
№2025/_____**

2025 оны дугаар сарын -ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “_____” (иргэн, компани) /цаашид “Үйлчлүүлэгч эсвэл захиалагч” гэх/ нөгөө талаас “БИ ТИ ЖИ ТИ” ХХК /цаашид “Нийлүүлэгч эсвэл гүйцэтгэгч” гэх, хамтад нь “талууд” гэх/ нар дор дурьдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал захиалагч талын Андроид системтэй гар утсанд НӨАТУС програм суулгаж, тасралтгүй найдвартай ажиллагааг хариуцан ажиллах, захиалагч нь гүйцэтгэгчид тохиролцсон хөлсийг төлөхөд оршино.
- 1.2 Гүйцэтгэгч нь захиалагч талын гар утаснуудад хяналтын программ хангамжийг заасан хугацаанд нийлүүлж, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, нөгөө талаас захиалагч нь заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгчид ажлын хөлсийг төлнө.
- 1.3 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Нийлүүлэгч тал нь үйлчлүүлэгч талын бүх мэдээлэл, Гар утасны мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг бусдад дамжуулан задруулахгүй байх үүрэгтэй.
- 2.2 Үйлчилгээний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 2.3 Захиалагч талын удирдлага, худалдааны төлөөлөгч, ахлах ажилтан зэрэг шаардлагатай бүх ажилчдад програм хангамжийг ажиллуулах энгийн зөвлөгөө өгч, гарын авлагаар хангах үүрэгтэй.
- 2.4 Гар утасны програм баталгаат хугацаандаа үйлчлүүлэгч талаас үл хамааран алдаа гарсан, эвдэрсэн тохиолдолд үнэ төлбөргүй засварлах үүрэгтэй.
- 2.5 Үйлчлүүлэгчийн програмд оруулсан мэдээллийг 24 цагийн дотор МТА-ны цахим татварын системд илгээнэ.

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Гүйцэтгэгч талд төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 3.2 Гар утасны програмд гарсан аливаа гэмтэл доголдлыг гүйцэтгэгч талд мэдэгдэж засуулах эрхтэй.
- 3.3 Гар утас буюу хэвлэгч төхөөрөмжийн механик эвдрэл гэмтлийг үйлчлүүлэгч тал өөрөө хариуцан арилгах үүрэгтэй.
- 3.4 Програм хангамжийг нийлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулан ашигласантай холбоотой гарах аливаа хариуцлагыг үйлчлүүлэгч тал бүрэн хүлээнэ.
- 3.5 Үйлчлүүлэгч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгч талын ажлын байранд очиж үйлчилгээ авна.

ДӨРӨВ. ГАР УТАСНЫ ПРОГРАМЫН БАТАЛГАА

- 4.1 Гар утасны програмын хэвийн ажиллагаа алдагдсан болон ажиллагаагүй болсон дараахь тохиолдолд нийлүүлэгч тал хариуцлага хүлээхгүй болно.
 - 4.1.1 Тухайн гар утас эвдэрч гэмтсэн ажиллагаагүй болсон.
 - 4.1.2 Гар утасны 3G, GPRS, интернэт холболт тасалсан нэгж дууссан.
 - 4.1.3 Гар утас дээр өндөр ачаалалтай програм давхар ажиллаж байх үед /video, chat, messenger, youtube, гэх мэт/.
 - 4.1.4 Програмыг гар утаснаас устгасан.
- 4.2 Дээрх заалтуудаас бусад гэмтлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж засварлах үүрэгтэй.

4.3 Баримт хэвлэгчийн баталгаат хугацаа 3 сар байна. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн баталгаат хугацаа тооцогдоно.

ТАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

5.1 НӨАТУС баримт хэвлэгч програмыг нэг утасанд суулгаж ашиглах төлбөр 1 жилд : 250,000 төгрөг.

5.2 Хэвлэгч төхөөрөмжний төлбөр (58мм өргөн) : 280,000 төгрөг.

5.3 Нийт дүн : төгрөг.

5.4 Програм ашигласаны төлбөрийг жил бүр гүйцэтгэгчид талд уридчилан төлж гэрээг сунгана.

5.5 Төлбөр төлөх данс : Хаанбанк 5007 355 133 Хүлээн авагч : БИ ТИ ЖИ ТИ ХХК

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1 Гэрээнд заасан хугацаанд талууд хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана. /Гэрээний хугацаанд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

6.2 Гүйцэтгэгч талаас шалтгаалахгүйгээр программ хангамжийн тасралтгүй ажиллагаанд нөлөөлөх, шилэн кабель тасалдах, цахилгаан доголдох, үүрэн холбооны сүлжээ тасалдах, гэмт халдлага, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүссэн аливаа эрсдэлд талууд хариуцлага хүлээхгүй.

ДОЛОО. ОЮУНЫ ӨМЧ

7.1 Энэхүү гэрээний дагуу үйлчлүүлэгч талд нийлүүлж байгаа програм хангамж болон програм хангамжид оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь гүйцэтгэгчийн оюуны өмч болно.

7.2 Захиалагч нь програм хангамжийг бусдад ашиглуулах, худалдаалах эрхгүй.

7.3 Програмд оруулсан хэрэглэгчийн мэдээлэл түүх нь гүйцэтгэгчийн өмч болохгүй.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд харьяа шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.2 Талуудын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагч, өмчлөгчид нь өөрчлөгдөхөөс үл хамааран энэхүү гэрээ үйлчлэх хугацааныхаа туршид хүчин төгөлдөр байна.

8.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж захиалагч нь 1 хувь, гүйцэтгэгч нь 1 хувийг хадгалах ба энэ нь хуулийн хувьд адил хүчинтэй байна.

ЕС. ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

“.....”

“БИТИЖИТИ” ХХК

Хаяг:

Хаяг: Улаанбаатар хот ХУД 03-р хороо

.....

Лайт тауэр оффис цэнтр 1402 тоот

Утас:....., факс :

Утас:77720000

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

Үйлчлүүлэгчийг төлөөлж:

Нэр :

РД:

Утас :

Гарын үсэг:

Нийлүүлэгчийг төлөөлж:

Ажилтан : Захирал

Нэр : Л.Гантулга

Утас :88889131

Гарын үсэг:.....